



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 5/18

Баянхутаг сум

Урамшуулал олгох тухай

Монгол Улсын захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ний өдрийн А/469 дүгээр захирамж, Аймгийн Онцгой байдлын газрын даргын 2024 оны 37/354 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний бие бялдарыг хөгжүүлэх, гамшигтай тэмцэх ур чадварыг дээшлүүлэх, гамшгийн аюулаас нэрвэгсдийг аврах, эрэн хайх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг дадлага олгох зорилготой аймгийн аварга шалгаруулах "Аврагч-2024" тэмцээнд сумын гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийг бэлдэн оролцуулж тэргүүн байр эзэлсэн тул Сумын Засаг даргын тамгын газрын дарга Б.Золбоогийн ажлын үр дүнг үндэслэн сарын үндсэн цалингийн 50 /Тавь/ хувийн урамшуулал олгосугай.

2. Урамшуулал олгохыг Нягтлан бодогч /Г.Пүрэвдулам/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.АМГАЛАНБАТ